

**“ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАРТ ГАЛ УНТРААХ ТУСГАЙ
ЗОРИУЛАЛТЫН МАШИН НИЙЛҮҮЛЭХ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН САНХҮҮГИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН
БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ АЮУЛГҮЙ
БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 01 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцүүлэх үед Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Г.Амартүвшин нар хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, Онцгой байдлын ерөнхий газарт хөөсөөр гал унтраах тоног төхөөрөмж хичнээн байгаа, сүүлийн үед баригдсан, баригдаж байгаа 12 давхраас дээш өндөр давхартай барилга, байгууламжид галын нэгдсэн систем, гал унтраах төхөөрөмж суурилагдсан болон суурилагдаж байгаа эсэх, төслийн хүрээнд худалдан авах гал унтраах тусгай зориулалтын машины шинэ эсэхийг, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат уг зээл нь Засгийн газрын өрийн хязгаарт багтаж байгаа эсэх, эдгээр тусгай зориулалтын машины засвар үйлчилгээг хэрхэн шийдэх, техникийн үйлчилгээ үзүүлэх нэгж нь Монгол Улсад байгуулагдах боломжтой талаар ажлын хэсгээс тодруулан асууж, хариулт авсан болно.

“Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Б.ЭНХ-АМГАЛАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ний ны өдөр

Төрийн өрдөн, Улаанбаатар
хот

САНХҮҮГИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. ~~"Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл" ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хооронд 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан "Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл"-ийн Санхүүгийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.~~

Гарын үсэг